



**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР**

**МОНГОЛ УЛСЫН
2020 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Улаанбаатар хот

2021 он

АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА 2	
МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН 2020 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	3
1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ.....	7
1.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого	8
1.2. Нэгдсэн төсвийн зарлага	9
1.3. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр.....	10
1.4. Төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал	12
1.5. Татварын зарлага	15
1.6. Худалдан авсан бараа, ажил үйлчилгээ	16
1.7. Нэмэлт төсөв	18
2. МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ	19
2.1. Улсын төсвийн орлого	19
2.2. Улсын төсвийн зарлага.....	21
2.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалт	22
2.4. Засгийн газрын нөөц сан	25
3. ИРЭЭДҮЙН ӨВ САН.....	26
4. ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	27
5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ	28
6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ	29
7. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ	30
8. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР	32
8.1. ДОТООД ҮНЭТ ЦААС	34
8.2. ГАДААД ҮНЭТ ЦААС	35
8.3. ГАДААД ЗЭЭЛ.....	36
8.4. ТӨСВӨӨС ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ КОНЦЕСС	37
8.5. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА	38
8.6. ДАМЖУУЛАН ЗЭЭЛ	39
9. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭ	41

МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гарган, танилцуулж байна.

Танилцуулгад улсын төсвийн 32 ерөнхийлөн захирагчийн 1,000 төсөвт байгууллага, нийслэл, дүүргүүд болон 21 аймгийн 3,336 төсөвт байгууллагууд, Ирээдүйн өв сан, Тогтворжуулалтын сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангуудын төсвийн гүйцэтгэл хамрагдсан болно. Түүнчлэн төсвийн тухай хуулийн дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланд татварын зарлагын тайлан, худалдан авсан ажил үйлчилгээний тайлан, хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, үр дүнгийн танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэл зэргийг нэгтгэн танилцуулж байна.

Төсөв, эдийн засгийн голлох үзүүлэлтүүд 2020 онд:

- Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2020 онд 10,444.2 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 4,440.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.
- Төсвийн тогтворжуулалтын санд 66.2 тэрбум, Ирээдүйн өв санд 914.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн байна.
- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үр нөлөөгөөр эдийн засаг 2020 оны эхний хагаст огцом суларсан хэдий ч ААН, иргэдийн орлогыг хамгаалах чиглэлд төсөв, мөнгөний бодлогыг хэрэгжүүлсний улмаас сүүлийн хагас жилд идэвхжил сэргэж, жилийн дүнгээр эдийн засаг урьдчилсан гүйцэтгэлээр 2020 онд 5.3 хувиар агшлаа.
- Эдийн засгийн идэвхжил 2020 онд сул байсан тул Засгийн газраас төсвийн зардлыг нэмэгдүүлэх замаар нийт эрэлтийг дэмжиж, мөчлөг сөрсөн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн нь ДНБ-ий агшилтыг хязгаарлахад чухал хувь нэмэр оруулсан байна.
- Засгийн газрын гадаад үнэт цаасыг дахин санхүүжүүлэх зорилгоор “Номад” бондыг арилжаалж, Мазаалай болон Чингис бондын нийт 568.2 сая ам.доллар буюу 1,622.1 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийг хугацаанаас өмнө төлж барагдуулсан.
- Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2020 онд 12.9 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 6.4 хувиар буурсан боловч гадаад худалдааны тэнцэл 2,282.4 сая ам.долларын ашигтай гарсан байна.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН 2020 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ

Эдийн засгийн өсөлт. Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2020 онд өмнөх онтой харьцуулахад урьдчилсан гүйцэтгэлээр 5.3 хувиар агшлаа. 2020 оны эдийн засгийн өсөлт төсвийг анх батлуулах үеийн төсөөллөөс 11 орчим нэгж хувиар, төсөвт тодотгол хийх үеийн төсөөллөөс 4 орчим нэгж хувиар бага гүйцэтгэлтэй гарсан байна. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үр нөлөөгөөр эдийн засаг жилийн эхний хагаст 9.7 хувиар агшсан бол экспортыг нэмэгдүүлэх, иргэд, аж ахуйн нэгжүүдийн орлогыг хамгаалах чиглэлд төсөв, мөнгөний бодлогыг хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор сүүлийн хагас жилд эдийн засгийн уналт саарсан байна. 2020 онд эдийн засаг нийт дүнгээр агшсан хэдий зарим салбарууд тухайлбал хөдөө аж ахуйн салбар 6.2 хувь, цахилгаан үйлдвэрлэл 2.0 хувь, боловсруулах үйлдвэрлэл 1.3 хувь, мэдээлэл холбооны салбар 0.4 хувиар тус тус өсөлттэй гарчээ.


Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлт, салбаруудаар

	2017	2018	2019	2020*
Эдийн засгийн өсөлт	5.3	7.2	5.2	-5.3
Хөдөө аж ахуй	1.8	4.5	8.4	6.2
Үйлдвэрлэл	0.7	7.4	2.9	-6.2
Уул уурхай	-5.5	5.7	-0.4	-9.4
Боловсруулах	19.9	15.7	10.9	1.3
Цахилгаан	5.0	8.2	5.3	2.0
Барилга	11.4	2.4	8.0	-7.4
Үйлчилгээ	7.7	5.0	5.8	-7.1
Худалдаа	6.8	3.4	7.9	-11.1
Тээвэр	14.2	7.6	2.0	-20.1
Мэдээлэл, холбоо	13.3	7.8	7.5	0.4
Бусад	5.4	4.8	5.6	-0.8
Цэвэр татвар	18.5	20.1	5.4	-9.8

Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо урьдчилсан гүйцэтгэл*

Инфляц. Хэрэглээний үнийн индексээр тооцсон жилийн инфляцын түвшин цар тахлын нөлөөгөөр 2020 онд 2.3 хувьд хүрч, өмнөх оноос 3 нэгж хувиар бага гарлаа. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас 2020 онд дотоодын эдийн засгийн идэвхжил сул байсан, иргэдийн хөл хөдөлгөөнд хязгаарлалт хийсэн, газрын тосны үнийг даган шатахууны үнэ буурсан, Засгийн газрын шийдвэрээр сайжруулсан шахмал түлшний үнийг бууруулсан зэрэг шалтгаануудын улмаас инфляц төсөв батлагдах үеийн төсөөллөөс 3.7 нэгж хувиар, төсвийн тодотгол батлагдах үеийн төсөөллөөс 1.5 нэгж хувиар бага гүйцэтгэлтэй гарсан байна.

График 1. Инфляцын түвшин



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо* урьдчилсан гүйцэтгэл

Засгийн газраас коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулах, өрх, аж ахуй нэгжид дэмжлэг үзүүлэх зорилгоор “Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшийг 75 хувиар хөнгөлсөн нь орон сууц, ус, цахилгаан бүлгийн үнийн индексийг бууруулж, улмаар инфляцыг бууруулахад голлох нөлөө үзүүлээ.


Гадаад худалдаа.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2020 онд 12.9 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 6.4 хувиар буурсан бол гадаад худалдааны тэнцэл 2,282.4 сая ам.долларын ашигтай байна.

2020 онд экспортоор 7.6 тэрбум ам.долларын бараа, түүхий эд гаргаснаар 2019 онтой харьцуулахад 0.6 хувиар буурсан байна. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тархалттай холбоотойгоор дотоодын үйлдвэрлэл саарч, хилийн боомтуудын үйл ажиллагаа удааширснаар экспортын хэмжээ саарсан зэрэг шалтгаануудын улмаас гадаад худалдааны эргэлт төсөв батлагдах үеийн төсөөллөөс 1.6 тэрбум ам.доллароор бага гүйцэтгэлтэй гарсан байна. Уул уурхайн салбарын голлох бүтээгдэхүүн болох нүүрсний экспорт 30.9 хувиар, газрын тосны экспорт 58.8 хувиар, жоншны экспорт 23.5 хувиар, цайрын баяжмалын экспорт 11.3 хувиар тус тус буурсан. Мөн уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт 37.5 хувиар буурчээ.

Импортоор 2020 онд 5.3 тэрбум ам.долларын бараа, түүхий эд авсан нь өмнөх оны мөн үеэс 13.6 хувиар буурчээ. Уул уурхайн үйлдвэрлэл саарсан, автобензин, дизель түлш, автомашин, машин, механизм болон тэдгээрийн эд ангийн импорт буурсан нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

График 2. Гадаад худалдаа /тэрбум төгрөг/



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

Төлбөрийн тэнцэл.

Төлбөрийн тэнцэл 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 787 сая ам.долларын ашигтай гарлаа. Данснудаар авч үзвэл, урсгал ба хөрөнгийн данс 572 сая ам.долларын алдагдалтай буюу ДНБ-ий 4.4 хувьтай тэнцэж байна. Харин санхүүгийн данс 1.5 тэрбум ам.долларын ашигтай буюу ДНБ-ий 11.3 хувьтай тэнцэж байна. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөгөөр дэлхий даяар үйлчилгээний салбарын үйл ажиллагааны идэвх саарч, манай улсын төлбөрийн тэнцэл дээрх үйлчилгээний алдагдал буурлаа. Энэ нь нүүрсний экспорт буурсантай холбоотойгоор нүүрс тээврийн үйлчилгээний зардал буурсан, хил хаасантай холбоотойгоор аяллын үйлчилгээний зардал буурсан, Оюу-Толгойн менежментийн зардал буурсантай холбоотойгоор бизнесийн үйлчилгээний зардал буурсан зэрэгтэй холбоотой байна.

График 3. Төлбөрийн тэнцэл




Гадаадын шууд хөрөнгө оруулалтын (хөрөнгө оруулалтын буцаалтыг оруулсан) цэвэр орох урсгал 2020 онд өмнөх оноос 32 хувиар буурч, 1.6 тэрбум ам.долларт хүрсэн ба энэ нь хувьцаа хэлбэрийн хөрөнгө оруулалт 54 хувиар буурсантай холбоотой байна. Харин өрийн хэрэгслээрх хөрөнгө оруулалтын урсгал өмнөх оны түвшинд байна. ГШХО-ын орох урсгалын дийлэнх хувийг эзэлж буй Оюу Толгойн хөрөнгө оруулалт 1 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 300 орчим сая ам.доллороор буурсан байна (Рио Тинто компанийн 2020 оны тайлан).

Мөн цар тахалтай холбоотой зээллэгүүд болон ОУВС-гийн Шуурхай санхүүжилтийн хөтөлбөр (RFI)-тэй холбоотойгоор засгийн газрын гадаад зээлийн ашиглалтын хэмжээ эрс нэмэгдсэн байна. Хувийн салбарын хувьд гадаад зээлийн төлөлт нь ашиглалтаасаа давсан үзүүлэлттэй байна.

1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2020 онд 10.4 их наяд төгрөгт хүрлээ. Үүнээс Төсвийн тогтворжуулалтын санд 66.2 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 914.1 тэрбум төгрөгийг хуваарилж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 9,463.8 тэрбум төгрөг болсон. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 13,904.3 тэрбум байна. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 4,440.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь Дотоодын нийт бүтээгдэхүүн¹-ий -12.0 хувьтай тэнцэж байна.

График 4. Монгол Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлт /2015- 2020 он, тэрбум төгрөг/



Тогтворжуулалтын сан. 2020 оны сүүлийн хагас жилд дэлхийн зах зээл дээрх зэсийн зах зээлийн үнэ харьцангуй өндөр гарсны улмаас Төсвийн тогтворжуулалтын санд төлөвлөсөн хэмжээнээс 11.1 тэрбум төгрөгөөр илүү буюу 66.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Ирээдүйн өв сан. Ирээдүйн өв санд 2020 онд 943.2 тэрбум төгрөг төвлөрөхөөр батлагдсанаас 914.1 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөсөн хэмжээнээс 29.1 тэрбум төгрөгөөр буюу 3.1 хувиар дутуу төвлөрсөн байна.

¹ ДНБ-ний урьдчилсан гүйцэтгэл, оны үнээр – 36,958,550.1 сая төгрөг
Эх сурвалж Үндэсний статистикийн хороо

1.1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2020 онд 9,463.8 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 4.3 хувь буюу 420.8 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэлийг 2019 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 1,441.7 тэрбум төгрөгөөр буюу 13.2 хувиар буурсан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлийг төсөв тус бүрээр нь авч үзвэл улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 91.3 хувь, орон нутгийн төсвийн орлогын биелэлт 95.0 хувь, эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын биелэлт 94.1 хувь, нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлт 103.6 хувь байна.

Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн орлого /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,883.0	10,441.2	96.0	(432.7)
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	943.2	914.1	96.9	(29.1)
ИРЭЭДҮЙН ӨВ САН	55.2	66.2	120.1	11.1
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	9,884.6	9,463.8	95.7	(420.8)
1.Татварын орлого	8,905.9	8,511.6	95.6	(394.3)
Орлогын албан татвар	2,564.3	2,227.3	86.9	(337.0)
Нийгмийн даатгалын орлого	1,522.4	1,586.0	104.2	63.6
Хөрөнгийн албан татвар	175.3	154.9	88.4	(20.4)
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,278.0	2,209.0	97.0	(69.0)
Онцгой албан татвар	734.9	776.9	105.7	42.0
Тусгай зориулалтын орлого	16.0	17.1	107.0	1.1
Гадаад үйл ажиллагааны орлого	771.0	740.7	96.1	(30.2)
Бусад татвар, төлбөр, хураамж	844.0	799.7	94.8	(44.3)
2.Татварын бус орлого	978.7	952.2	97.9	(20.4)

Тайлант онд татварын орлогын бүрдүүлэлт 8,511.6 тэрбум төгрөгт хүрч, 95.6 хувийн гүйцэтгэлтэй гарлаа. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 63.6 тэрбум төгрөг, онцгой албан татвар 42.0 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс давсан боловч аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 337.0 тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 69.0 тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 30.2 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс дутуу биелсэн нь татварын орлогын гүйцэтгэл төлөвлөсөн дүнгээс 394.3 тэрбум төгрөгөөр тасрахад голлон нөлөөлсөн байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг үе шаттай хөл хорио, хязгаарлалтууд тогтоосны улмаас бизнесийн идэвхжил саарч гол нэрийн эрдэс бүтээгдэхүүний экспортын хэмжээ буурч, уул уурхай, бөөний худалдаа зэрэг голлох салбаруудын орлого тасалдсан нь татварын орлогын гүйцэтгэлд голлон нөлөөлсөн.

1.2. НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2020 онд 13,904.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 8.1 хувь буюу 1,233.0 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн зарлага /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,137.3	13,904.3	(1,233.0)
А. УРСГАЛ ЗАРДАЛ	11,568.9	10,829.0	(739.9)
1. Бараа, ажил үйлчилгээний зардал	5,257.9	4,851.2	(406.7)
1. Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,716.5	2,648.9	(67.6)
2. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	305.6	279.8	(25.8)
3. Хангамж, бараа материалын зардал	191.4	172.3	(19.1)
4. Норматив зардал	408.1	354.3	(53.8)
5. Эд хогшил, урсгал засварын зардал	136.1	124.2	(11.8)
6. Томилот, зочны зардал	25.9	16.5	(9.4)
7. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	912.3	783.4	(129.0)
8. Бараа үйлчилгээний бусад зардал	562.1	471.9	(90.2)
2. Хүү	979.0	939.2	(39.8)
3. Татаас	458.2	375.1	(83.2)
4. Урсгал шилжүүлэг	4,873.8	4,663.5	(210.3)
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,514.0	3,034.2	(479.8)
1. Барилга байгууламж	2,368.0	2,072.0	(296.0)
2. Их засвар	172.2	145.0	(27.2)
3. Тоног төхөөрөмж	470.8	420.8	(50.0)
4. Бусад хөрөнгө	483.3	376.7	(106.5)
5. Стратегийн нөөц хөрөнгө	19.8	19.8	(0.0)
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	54.3	41.1	(13.2)
1. Эргэж төлөгдөх зээл	(170.2)	(119.5)	50.7
2. Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	224.5	160.6	(63.9)

Хөрөнгийн зардал 479.8 тэрбум төгрөг, бараа, ажил үйлчилгээний зардал 406.7 тэрбум төгрөг, урсгал шилжүүлгийн зардал 210.3 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан нь нийт зардлын гүйцэтгэлд голлон нөлөөлсөн байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөв тус бүрээр ангилан харуулбал; улсын төсөв 7.9 хувь буюу 917.6 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв 15.1 хувь буюу 560.7 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 13.8 хувь буюу 68.2 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын сангийн төсөв 1.7 хувь буюу 42.2 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөсөн дүнгээс дутуу байна.

Хүснэгт 4. Төсвүүдийн нийт зарлага ба цэвэр зээл / тэрбум төгрөг/

Төсвийн бүрэлдэхүүн	2020 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Нэгдсэн төсөв	15,137.3	13,904.3	(1,233.0)
Улсын төсөв	11,653.3	10,735.6	(917.6)
Орон нутгийн төсөв	3,717.9	3,157.2	(560.7)
Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв	494.5	426.4	(68.2)
Нийгмийн даатгалын сангийн төсөв	2,494.0	2,451.8	(42.2)

1.3. НЭГДСЭН ТӨСВИЙН АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР

Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 4,440.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

Хүснэгт 5. Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл /тэрбум төгрөг/

Төсвийн бүрэлдэхүүн	2020 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Нэгдсэн төсөв	(5,252.7)	(4,440.4)	818.3
Улсын төсөв	(4,176.7)	(3,906.6)	276.2
Орон нутгийн төсөв	(406.2)	(10.4)	395.8
Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв	12.0	50.1	38.1
Нийгмийн даатгалын сангийн төсөв	(681.8)	(573.6)	108.2

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 3,906.6 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийн тэнцэл 10.4 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл 573.6 тэрбум төгрөгийн алдагдалтай, харин Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тэнцэл 50.1 тэрбум төгрөгийн ашигтай байна.

Тайлант онд Засгийн газрын гадаад үнэт цаасны үндсэн төлбөр болон урамшуулалд 1,679.0 тэрбум төгрөг, гадаад зээлийн үндсэн төлбөрт 691.1 тэрбум төгрөг, дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 263.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2020 онд Төсвийн тогтворжуулалтын сангаас Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.4-т заасны дагуу 138.8 тэрбум төгрөгийг тухайн жилийн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор улсын төсөвт шилжүүлсэн.

Хүснэгт 6. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлсэн эх үүсвэр/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Нэгдсэн төсөв	Улсын төсөв	Орон нутгийн төсөв	ЭМДС	НДС
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-4,440.4	-3,906.6	-10.4	50.1	-573.6
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,440.4	3,906.6	10.4	-50.1	573.6
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	332.8	1,868.4	-10.4	-50.1	573.6

ЗГ-ын бонд	(249.4)	(249.4)	0.0	0.0	0.0
Урт хугацаат	(249.4)	(249.4)	0.0	0.0	0.0
Дотоод	(263.0)	(263.0)	0.0	0.0	0.0
Үндсэн төлбөр	(263.0)	(263.0)	0.0	0.0	0.0
Гадаад	13.6	13.6	0.0	0.0	0.0
Шинээр гаргах	1,692.6	1,692.6	0.0	0.0	0.0
Үндсэн төлбөр	(1,679.0)	(1,679.0)	0.0	0.0	0.0
ЗГ-ын зээл	2,661.4	2,661.4	0.0	0.0	0.0
Гадаад	2,661.4	2,661.4	0.0	0.0	0.0
Төслийн зээл	683.3	683.3	0.0	0.0	0.0
Шинээр авах	1,374.4	1,374.4	0.0	0.0	0.0
Үндсэн төлбөр	(691.1)	(691.1)	0.0	0.0	0.0
Хөтөлбөрийн зээл	1,978.1	1,978.1	0.0	0.0	0.0
Шинээр авах	1,978.1	1,978.1	0.0	0.0	0.0
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	138.8	138.8	0.0	0.0	0.0
Өмч хувьчлал	21.2	0.4	20.8	0.0	0.0

1.4. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙДАЛ

Төсвийн орлогын тусгай шаардлага: Монгол Улсын 2020 оны төсвийн орлогын төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан “Төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох” тусгай шаардлагын дагуу боловсруулан батлуулж, төсвийн жилийн турш уг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан ажиллалаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т заасны дагуу гол нэр төрлийн эрдэс баялгийн 2020 онд баримтлах тэнцвэржүүлсэн үнийг Олон улсын валютын сан болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн төсөөлөл хийдэг олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагаас гаргасан өмнөх 20 жилийн үнийн дундаж болон тухайн төсвийн жил, түүний дараах 3 жилийн дундаж үнийн төсөөллийг дундажлан тус тус тооцсон.

Эрдэс бүтээгдэхүүний үнийн төсөөллийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан зарчмын дагуу олон улсад нийтлэг хэрэглэдэг “Bloomberg”, “Чикаго металлын бирж” мэдээллийн эх сурвалжаас авч ашиглаж 2020 онд нэг тонн зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 6,290.5 ам.доллар, нүүрсний үнийг 75.5 ам.доллар байхаар тооцож, Төсвийн тогтворжуулалтын санд 55.1 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 7. 2020 он зэсийн зах зээлийн үнэ

Бүтээгдэхүүний төрөл	Төлөвлөгөө	Тэнцвэржүүлсэн	Гүйцэтгэл	Зөрүү
Зэс, ам.доллар	5,940.9	6,290.5	6,168.5	227.6

Дэлхийн зах зээл дээрх зэсийн зах зээлийн үнэ 2020 оны сүүлийн хагас жилд харьцангуй өндөр гарсны улмаас Төсвийн тогтворжуулалтын санд төлөвлөсөн хэмжээнээс илүү буюу 66.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Төсвийн тэнцлийн тусгай шаардлага: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх” гэж заасныг 2013 оны төсвийн жилээс хэрэгжүүлж эхэлсэн.

Улсын Их Хурлаас төсвийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-ийн тусгай шаардлагад 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. Үүнд “Энэ хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2017 онд 10.4 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 5.1 хувиас, 2021 онд 3.6 хувиас, 2022 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2023 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна.” гэж тусгасан.

Хүснэгт 8. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн гүйцэтгэл

		2020 он
1	Хуулиар тогтоосон хязгаар	-5.1%
2	Гүйцэтгэл	-12.0%

2020 оны төсвийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэл - 4,440.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -12.0 хувьтай тэнцэж байна.

Харин “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д:

8.1.Төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг дараах тохиолдолд түр хугацаагаар түдгэлзүүлж болно:

8.1.1.тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт нь өмнөх жилтэй харьцуулахад “0”, эсхүл түүнээс бага, хасах хувьтай бол;

8.1.2.гамшгийн аюулын хор уршиг, онцгой нөхцөлийн үр дагаврыг арилгахад төсвөөс нэмж шаардагдах санхүүжилтийн хэмжээ нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувь ба түүнээс дээш хэмжээнд хүрэхээр бол.

гэж заасан ба 2020 онд дэлхий нийтэд тархсан Коронавируст халдварын цар тахлаас үүдэн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт өмнөх онтой харьцуулахад хасах хувьтай байсан тул “Төсвийн зарим тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх, мөрдөх хугацааг хойшлуулах тухай” хуулийн төслийг 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хурлаар баталсан болно.

Зарлагын өсөлтийн тусгай шаардлага: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т “тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх” гэж заасан.

Хүснэгт 9. Зарлагын өсөлтийн үзүүлэлтүүд

		2020 он
1	Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь	19.2%
2	Тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь	6.8%
3	Тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дундаж	19.8%

Өрийн тусгай шаардлага: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2020 оны төсвийн жилд 70 хувиас хэтрүүлэхгүй байхаар заасан.

Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2020 оны эцэст 27.9 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 23.0 их наяд төгрөг буюу ДНБ-ий 62.3 хувьтай тэнцүү байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан өрийн тухай тусгай шаардлагыг бүрэн хангаж байна.

1.5. ТАТВАРЫН ЗАРЛАГА

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.25-д “татварын зарлага” гэж татварын хуулиар тухайн жилд татвар төлөгчид олгох татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэлнэ, мөн Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлд татварыг зөвхөн хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй гэж тус тус заасан.

Хууль тогтоомжийн дагуу олгосон татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 2020 оны гүйцэтгэлээр 906.8 тэрбум төгрөг² буюу нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 9.6 хувийг эзэлж байна. Татварын зарлагын хэмжээг татвар, гаалийн байгууллагаар харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 10. Татварын зарлагын хэмжээ/тэрбум төгрөг/

Байгууллага	2020 он	Бүтэц хувиар
Татварын байгууллага	703.8	77.6%
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	201.5	22.2%
Хувь хүний орлогын албан татвар	386.9	42.7%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	115.4	12.7%
Гаалийн байгууллага	203.0	22.4%
Гаалийн албан татвар	30.8	3.4%
Онцгой албан татвар	104.0	11.5%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	68.1	7.5%
Нийт татварын зарлага	906.8	100.0%

Хүснэгтээс харахад нийт татварын зардал буюу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн 77.6 хувь буюу 703.8 тэрбум төгрөгийг татварын алба, 22.4 хувь буюу 203.0 тэрбум төгрөгийг гаалийн байгууллага эдлүүлсэн байна.

² Сангийн сайдын 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 99 дугаар тушаалаар батлагдсан “Татварын зарлагад шинжилгээ хийх, гүйцэтгэлийг тайлагнах журам”-д заасны дагуу зарим төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг татварын зарлагад хамруулахгүйгээр тусгасан бөгөөд журамд заасны дагуу татварын зарлагын гүйцэтгэлийн мэдээг гаргав..

1.6. ХУДАЛДАН АВСАН БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай 2020 оны нэгдсэн тайлангаас үзэхэд Монгол Улсын хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр нийт 3,550.6 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Хүснэгт 11. Нийт худалдан авалтад тендер шалгаруулалтын журмыг хэрэглэсэн байдал/тэрбум төгрөг/

Д/д	Худалдан авалтын төрөл	Тендер шалгаруулалт зарласан тоо	Дүн	Хувь
1	Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар	5,087	2,250.8	63.45
2	Шууд гэрээ байгуулах аргаар	1,395	1,050.0	29.5
3	Харьцуулалтын аргаар	3,995	140.5	3.96
4	Шууд худалдан авалтаар	4,321	29.1	0.82
5	Хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргаар	471	60.9	1.72
6	Олон нийтийн оролцооны аргаар	83	1.00	0.03
7	Зөвлөх үйлчилгээний журмаар	299	18.3	0.52
Нийт худалдан авалт		15,651	3,550.6	100.0

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланд Сангийн сайдын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах” журмын 3 дугаар хавсралтад тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг хийлээ.

Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр 2020 онд нийт 4,706.7 тэрбум төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж, нийт 3,547.6 тэрбум төгрөгийн өртөг бүхий гэрээ байгуулж ажилласан байна. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх нийт 1,347 төсөл, арга хэмжээнд 1,330.8 тэрбум төгрөг батлагдаж 1,093.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож гүйцэтгэл 82.17 хувьтай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 оны худалдан авах ажиллагаанд өгсөн үнэлгээний дүнгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Батлан хамгаалахын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайд, Архангай аймгийн Засаг дарга, Баянхонгор аймгийн Засаг дарга, Говьсүмбэр аймгийн Засаг дарга, Дархан-Уул аймгийн Засаг дарга, Дорноговь аймгийн Засаг дарга, Дорнод аймгийн Засаг дарга, Орхон аймгийн Засаг дарга, Сэлэнгэ аймгийн Засаг дарга, Төв аймгийн Засаг дарга, Увс аймгийн Засаг дарга, Ховд аймгийн Засаг дарга, Хөвсгөл аймгийн Засаг дарга, Хэнтий аймгийн Засаг дарга, Үндэсний статистикийн газрын дарга, Авлигатай тэмцэх газрын дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Улсын ерөнхий прокурор, Монгол Улсын ерөнхий аудитор, Үндсэн хуулийн цэцийн дарга нар 80-89 хувь буюу “Сайн”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,

Монгол Улсын Ерөнхий сайдын багц, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, Эрчим хүчний сайд, Монгол Улсын Шадар сайдын багц, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Гадаад харилцааны сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Зам тээврийн хөгжлийн сайд, Эрүүл мэндийн сайд, Баян-Өлгий аймгийн Засаг дарга, Булган аймгийн Засаг дарга, Говь-Алтай аймгийн Засаг дарга, Дундговь аймгийн Засаг дарга, Завхан аймгийн Засаг дарга, Өвөрхангай аймгийн Засаг дарга, Нийслэлийн Засаг дарга, Өмнөговь аймгийн Засаг дарга, Сүхбаатар аймгийн Засаг дарга, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Төрийн албаны зөвлөлийн дарга, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч нар 60-79 хувь буюу "Хангалттай", Барилга, хот байгуулалтын сайд, Хүний эрхийн Үндэсний комиссын дарга нар 40-59 хувь буюу "Хангалтгүй" үнэлгээ тус тус авсан байна.

Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 5 хоногийн дотор тендерт оролцогч нараас ирүүлсэн гомдлыг хүлээн авч 14 хоногт хянан хариу өгдөг. 2020 онд Сангийн яам 816 тендер шалгаруулалтын үнэлгээтэй холбогдуулан 560 аж ахуйн нэгжээс давхардсан тоогоор нийт 1,009 гомдлыг хянан шийдвэрлэсэн. Хүлээн авсан нийт гомдлын 134 буюу 13 хувийг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 184 гомдлоор багассан байна.

Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийх 590 шийдвэр, тендер шалгаруулалтыг хүчингүй болгох 71 шийдвэрийг захиалагч байгууллагад хүргүүлж, захиалагч буруу шийдвэр гаргасан байсныг тендерт оролцогчдын хяналтаар дамжуулан зохих шатанд нь залруулсан байна.

1.7. НЭМЭЛТ ТӨСӨВ

Нэмэлт төсвийн эх үүсвэрт 2020 онд 919.8 тэрбум төгрөг төвлөрсөн байна.

Нийт эх үүсвэрийн 404.9 тэрбум төгрөг буюу 44.0 хувь нь төсвийн эх үүсвэрээс, 514.9 тэрбум төгрөг буюу 56.0 хувь нь төсвийн бус эх үүсвэрээс санхүүжигдсэн байна. Эх үүсвэрийг ангилан үзэхэд:

- Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 271.4 тэрбум төгрөг;
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаар 174.3 тэрбум төгрөг;
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 340.6 тэрбум төгрөг;
- ЗГ-ын болон Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 133.5 тэрбум төгрөг тус тус төвлөрсөн байна.

Тайлант онд нэмэлт төсвөөр 950.4 тэрбум төгрөг зарцуулалт гарсан байна. Нийт зарлагын гүйцэтгэлийг сайдын багцуудаар авч үзвэл:

Батлан хамгаалахын сайдын зарлагын гүйцэтгэл 298.9 тэрбум төгрөг буюу нийт нэмэлт төсвийн зарлагын гүйцэтгэлийн 31.4 хувь, Улаанбаатар хотын зарлагын гүйцэтгэл 88.6 тэрбум төгрөг буюу 9.3 хувь, Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын зарлагын гүйцэтгэл 88.5 тэрбум төгрөг буюу 9.3 хувь, Эрүүл мэндийн сайдын зарлагын гүйцэтгэл 79.5 тэрбум төгрөг 8.4 хувь, Нийгмийн даатгалын сангийн зарлагын гүйцэтгэл 71.4 тэрбум төгрөг буюу 7.5 хувь, Шадар сайдын 36.1 тэрбум төгрөг буюу 3.8 хувь байна.

Нэмэлт төсвийн нийт зарлагыг эдийн ангиллаар нь авч үзвэл бараа үйлчилгээний бусад зардал 225.0 тэрбум төгрөг 23.7 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 179.8 тэрбум төгрөг 18.9 хувь, бусад урсгал шилжүүлгийн зардал 139.1 тэрбум төгрөг 14.6 хувь, томилолт, зочны зардал 60.9 тэрбум төгрөг 6.4 хувь, хөрөнгийн зардал 59.8 тэрбум төгрөг 6.3 хувь, цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 37.3 тэрбум төгрөг 3.9 хувь, эд хогшил, урсгал засварын зардал 36.2 тэрбум төгрөг 3.8 хувийг эзэлж байна.

2. МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ

Монгол Улсын төсөв нь нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн бөгөөд Монгол Улсын ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яамд болон тэдгээрийн харьяа байгууллагуудын бүрдүүлэн зарцуулах төсөв юм.

Монгол Улсын 2020 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 6,829.0 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 10,735.6 тэрбум төгрөгт хүрч, төсвийн тэнцэл 3,906.6 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

2.1. УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГО

Монгол Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2020 онд 6,829.0 тэрбум төгрөгт хүрч, 91.3 хувийн гүйцэтгэлтэй буюу төлөвлөгөөнөөс 647.5 тэрбум төгрөг дутуу, харин өмнөх оны гүйцэтгэлээс 1,148.6 тэрбум төгрөгөөр буюу 14.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 12. Улсын төсвийн орлогын гүйцэтгэл/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	8,474.9	7,809.3	(659.5)
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	943.2	914.1	(29.1)
ИРЭЭДҮЙН ӨВ САН	55.2	66.2	11.1
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,476.5	6,829.0	(641.4)
Татварын орлого	6,095.8	5,690.1	(405.7)
Орлогын албан татвар	1,736.4	1,398.5	(338.0)
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,278.0	2,209.0	(69.0)
Онцгой албан татвар	734.9	776.9	42.0
Тусгай зориулалтын орлого	16.0	17.1	1.1
Гадаад үйл ажиллагааны орлого	771.0	740.7	(30.2)
Бусад татвар, төлбөр, хураамж	559.6	548.0	(11.6)
Татварын бус орлого	1,380.7	1,138.9	(235.7)
Нийтлэг татварын бус орлого	602.8	587.9	(8.9)
Тусламжийн орлого	418.9	375.7	(43.2)
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	358.9	175.3	(183.6)

Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн 83.2 хувь татварын орлогоос, 16.8 хувь татварын бус орлогоос бүрдсэн байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цах тахлын үр нөлөөгөөр эдийн засаг агшиж, хил гаалийн нэвтрүүлэх хүчин чадал удааширсан, улмаар экспортлогч томоохон аж ахуйн нэгжийн олборлолт, борлуулалт буурснаас шалтгаалан аж ахуйн нэгжийн орлогын албан татварын гүйцэтгэл 338.0 тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татварын гүйцэтгэл 69.0 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс дутсан байна.

Мөн гадаад худалдааны нийт бараа эргэлт өмнөх оноос 6.4 хувиар буурсан нь гадаад үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс дутахад нөлөөлсөн байна.

Тайлант онд орон нутгийн төсвөөс улсын төсөвт 358.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 183.6 тэрбум төгрөг дутуу буюу 175.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2.2. УЛСЫН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Монгол Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2020 онд 10,735.6 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөнөөс 917.6 тэрбум төгрөг буюу 7.9 хувиар бага гарсан байна.

Улсын төсвийн урсгал зардалд 8,224.9 тэрбум, хөрөнгийн зардалд 2,487.5 тэрбум, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд 23.3 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 13. Улсын төсвийн зарлагын гүйцэтгэл/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,653.3	10,735.6	(917.6)
НИЙТ ЗАРЛАГА	11,633.5	10,712.3	(921.2)
УРСГАЛ ЗАРДАЛ	8,806.1	8,224.9	(581.2)
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,147.0	2,921.9	(225.1)
ХҮҮ	972.6	932.8	(39.8)
ТАТААС	633.6	564.7	(68.9)
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,052.9	3,805.4	(247.5)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,828.6	2,487.5	(341.1)
Дотоод эх үүсвэрээр	2,828.6	2,487.5	(341.1)
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	18.6	23.3	(4.7)

Улсын төсвөөс Нийгмийн даатгалын санд 399.4 тэрбум төгрөгийн татаас, орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэгээр 201.7 тэрбум төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтэд 1,333.9 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн санд хуваарилах орлогын шилжүүлгээр 165.7 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Гадаад зээлийн үйлчилгээний зардалд 775.8 тэрбум төгрөг, дотоод зээлийн үйлчилгээний зардалд 157.1 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Улсын төсвийн зарлага, санхүүжилтийг олгох зорилгоор Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас гаргаагүй нь хүүгийн зардлыг хэмнэхэд голлон нөлөөлсөн байна.

2.3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Монгол Улсын 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1,356 төсөл, арга хэмжээний 1,654.3 тэрбум төгрөг батлагдсанаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,347 төсөл, арга хэмжээний 1,330.8 тэрбум төгрөг, “Барих-шилжүүлэх” нөхцөлтэй концессын гэрээ байгуулсан төслүүдийн эргэн төлөлтөд 9 төсөл, арга хэмжээний 323.5 тэрбум төгрөг тус тус батлагдсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 1,347 төсөл, арга хэмжээнээс 844 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжиж, 503 төсөл, арга хэмжээ нь он дамжин хэрэгжсэн бөгөөд санхүүжилтийн гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 1,093.7 тэрбум төгрөг буюу 82.2 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 14. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл/тэрбум төгрөг/

Ангилал	Төслийн тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	2020.12.31-ний байдлаар		
				Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь	Үлдэгдэл санхүүжилт
НИЙТ	1,356	5,175.3	1,654.3	1,414.6	85.51	239.7
УЛСЫН ТӨСӨВ	1,347	4,118.2	1,330.8	1,093.7	82.17	237.2
КОНЦЕСС	9	1,057.1	323.5	320.9	99.22	2.5

Үүнээс, 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг төсвийн ерөнхийлөн захирагчдаар авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 15. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /сая төгрөг/

№	ТЭЗ	Төслийн тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	2020.12.31-ны байдлаар		
					Нийт гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь	Үлдэгдэл санхүүжилт
1	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	1	2,376.0	2,376.0	1,957.6	82.39%	418.4
2	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	40	192,477.8	30,854.2	23,949.5	77.62%	6,904.7
3	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	12	40,570.3	10,265.3	10,115.7	98.54%	149.6
4	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	80	96,591.6	47,256.6	42,947.3	90.88%	4,309.3
5	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	29	41,939.4	17,639.4	14,655.3	83.08%	2,984.1
6	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	5	23,033.1	9,037.0	9,030.9	99.93%	6.1
7	ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ	2	2,600.0	2,600.0	2,595.3	99.82%	4.7
8	САНГИЙН САЙД	11	265,998.1	102,588.1	80,113.8	78.09%	22,474.3
9	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	25	71,753.5	50,650.2	50,125.0	98.96%	525.2
10	ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	36	46,876.6	12,671.5	9,713.4	76.66%	2,958.1
11	БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	213	489,898.9	179,125.8	141,819.3	79.17%	37,306.5
12	БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	437	949,521.5	323,449.2	261,414.3	80.82%	62,034.9
13	СОЁЛЫН САЙД	115	671,079.7	144,335.8	105,453.6	73.06%	38,882.2
14	ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	127	656,573.5	209,387.5	190,902.7	91.17%	18,484.8
15	УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	4	5,815.0	4,087.9	3,766.4	92.14%	321.5
16	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	34	35,329.0	21,420.7	8,258.2	38.55%	13,162.5
17	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	30	194,891.5	32,270.9	18,411.9	57.05%	13,859.0

18	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	133	295,723.5	119,952.2	108,158.4	90.17%	11,793.8
19	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	2	1,070.7	1,070.7	1,066.8	99.63%	3.9
20	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	7	31,875.3	7,631.5	7,002.4	91.76%	629.1
21	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	2	1,000.0	1,000.0	990.0	99.00%	10.0
22	ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	1	600.0	600.0	592.1	98.69%	7.9
23	ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	1	585.0	585.0	582.9	99.63%	2.1
УЛСЫН ТӨСӨВ		1,347	4,118,180.0	1,330,855.3	1,093,622.7	82.17%	237,232.6
КОНЦЕСС		9	1,057,121.5	323,492.3	320,973.1	99.22%	2,519.2
НИЙТ ДҮН		1,356	5,175,301.5	1,654,347.6	1,414,595.8	85.51%	239,751.8

Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилт батлагдсанаас нийт санхүүжилтийн 19.5 хувь нь боловсрол, шинжлэх ухааны салбарт, 12.7 хувь нь зам тээврийн хөгжлийн салбарт, 10.8 хувь нь барилга, хот байгуулалтын салбарт, 7.2 хувь нь эрүүл мэндийн салбарт, үлдсэн нь бусад салбарт хэрэгжсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд дараах барилга байгууламж ашиглалтад орсон.

Хүснэгт 16. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд ашиглалтад орсон барилга байгууламж

№	Салбар, төслийн нэр	Нийт хүчин чадал	Хэмжих нэгж	Ашиглалтад орсон төслийн тоо
1	Боловсрол, шинжлэх ухааны салбар:			131
1.1.	Сургууль	10800	суудал	30
1.2.	Цэцэрлэг	8515	ор	64
1.3.	Дотуур байр	2145	ор	22
1.4.	Сургууль, цэцэрлэгийн цогцолбор	1200	ор/суудал	1
1.5.	Сургуулийн спорт заал	320	м2	11
1.6.	Их дээд сургууль	960	суудал	1
1.7.	Сургалтын төв			1
1.8.	Шинжлэх ухааны барилга			1
2	Эрүүл мэндийн салбар:			27
2.1.	Эрүүл мэндийн төв	195	ор	17
2.2.	Өрхийн эрүүл мэндийн төв			2
2.3.	Төрөх эмнэлэг	50	ор	1
2.4.	Нэгдсэн эмнэлэг	300	ор	2
2.5.	Сүрьеэгийн эмнэлэг			1
2.6.	Хүүхдийн эмнэлэг	100	ор	2
2.7.	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн III шатлалын лаборатори			1
2.8.	БОЭТ-ийн ариутгалын тасаг			1
3	Соёлын салбар:			25
3.1.	Соёлын төв	4240	суудал	17
3.2.	Кино театр			1
3.3.	Соёл, спортын төв, цогцолбор			7
4	Зам тээврийн салбар:			
4.1.	Авто зам	155.9	км	155.9
4.2.	Гүүрийн байгууламж	659.58	ү/м	659.58
5	Барилга хот байгуулалтын салбар:			59
5.1.	Инженерийн шугам сүлжээ			20
5.2.	Үерийн далан, байгууламж			3
5.3.	Гудамж талбайн гэрэлтүүлэг			8
5.4.	Бусад			28
6	Эрчим хүчний салбар:			12

6.1.	Цахилгаан дамжуулах шугам, дэд станц,			9
6.2.	Дулааны цахилгаан станц, дулааны шугам			3
7	Байгаль орчин, аялал жуулчлалын салбар:			5
7.1	Цаг уурын өртөө			5
8	Батлан хамгаалах салбар:			3
8.1.	Батлан хамгаалах удирдлагын академи	м2		1
8.2	Хичээлийн байр	м2		1
8.3	Зэвсэгт хүчний ангийн автомашины граж	м2		1
9	Хууль зүйн салбар:			10
9.1	Цагдаагийн хэлтсийн барилга	м2		5
9.2	Улсын бүртгэлийн архив, үйлчилгээний цогцолбор	м2		1
9.3	Архивын хэлтсийн барилга	м2		1
9.4	Хил хамгаалах салбарын нөхөн сэргээх төв	м2		1
9.5	Дотоод хэргийн их сургуулийн спорт цогцолбор, номын сан	м2		1
9.6	Цэргийн албан хаагчдын байр	м2		1
10	Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбар:			10
10.1	Ахмадын өргөөний барилга	м2		9
10.2	Усан спортын цогцолборын барилга	м2		1
11	Мэргэжлийн хяналт, онцгой, стандартын салбар:			7
11.1	Мэргэжлийн хяналтын лаборатори, контор	м2		5
11.2	Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилга	м2		1
11.3	Аврах гал унтраах барилга	м2		1
12	Гаалийн шинэчлэл:			7
12.1	Гаалийн шуурхай удирдлагын төв			1
12.2	Гаалийн хороо, гаалийн төв болон газар хороодын лабораторийн барилга			6
	НИЙТ			296

Концессын эргэн төлөлт:

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ барилга, байгууламжийн эргэн төлөлтийн жагсаалтаар концессын гэрээний дагуу 9 төсөл, арга хэмжээнд 323.5 тэрбум төгрөгийн санхүүжилт төлөвлөснөөс 320.9 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлж, гүйцэтгэл 99.2 хувьтай гарсан.

Концессын гэрээний дагуу өмнөх онуудад ашиглалтад орсон Алтай-Дарви чиглэлийн 263 км хатуу хучилттай авто зам төсөл, нийслэлийн Баянгол дүүргийн 38 дугаар сургууль, Баянхонгор аймгийн Өлзийт сумын 100 ортой цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажлын эргэн төлөлтөд 89.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож төлбөрийг бүрэн барагдуулсан.

2020 онд эргэн төлөлт олгогдсон төслөөс 4 төсөлд, тухайлбал “Чойр” дэд станцын өргөтгөл, шинэчлэлт”, “Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам” төсөл, “Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам” төсөл, “Төрөх эмнэлгийн барилгын дуусгал, дэд бүтэц, 300 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/” төсөл, арга хэмжээний эргэн төлөлтөд 231.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.

2.4. ЗАСГИЙН ГАЗРЫН НӨӨЦ САН

Монгол Улсын Засгийн газрын нөөц сангийн 2020 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлснээс гадна төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11.2-т “Засгийн газрын нөөц сан нь энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ” гэж заасны дагуу Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар Сангийн сайдын 2020 төсвийн багцад Засгийн газрын нөөц санг 100 хувь төсвөөс санхүүжихээр тусгасан. Засгийн газрын нөөц сангийн гүйцэтгэлийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 17. ЗГ-ын нөөц сангийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Дүн
2020 оны ЗГ-ын нөөц сангийн төлөвлөгөө	65.0
Засгийн газрын тогтоолын нийт дүн	82.8
Үүнээс: 2019 оны тогтоолын дүн	5.4
2020 оны тогтоолын дүн	77.4
Санхүүжүүлсэн нийт дүн	65.0
Санхүүжүүлээгүй дүн	-
Тогтоолын үлдэгдэл	17.8
Санхүүжүүлээгүй хүлээгдэж буй гүйцэтгэл	-

Засгийн газрын нөөц сан нь 2020 онд 65.0 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас 2020 онд Засгийн газрын 36 тогтоол 77.4 тэрбум төгрөгийг зарцуулахаар шийдвэрлэсэн байна. Засгийн газрын тогтоолын дагуу нийт 65.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2020 онд санхүүжүүлж, 100.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Засгийн газрын нөөц сангаас 2020 онд дэлхий нийтээр тархаад байгаа коронавируст цар тахалтай тэмцэх үйл ажиллагаанд 50.5 тэрбум төгрөг, байгалийн гамшиг, аюултай үзэгдлийн хохирол болон бусад арга хэмжээнд 14.5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

3. ИРЭЭДҮЙН ӨВ САН

Ирээдүйн өв сангийн тухай хууль 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болж хэрэгжиж эхэлсэн. Ирээдүйн өв сангийн орлогын үндсэн эх үүсвэр нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 65 хувь, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааны ногдол ашиг юм.

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д санд төвлөрүүлэх хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж батална гэж заасан бөгөөд тус санд 2020 онд 943.2 тэрбум төгрөг төвлөрөхөөр батлагдаж, 914.1 тэрбум төгрөг төвлөрөн 96.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Ирээдүйн өв сан нь Хүний хөгжил сангийн боловсронгуй хэлбэр байхаар байгуулагдсан бөгөөд Хүний хөгжил санг Ирээдүйн өв санд шилжүүлж байгаатай холбоотойгоор Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг Улсын Их Хурлаас баталсан.

Тус хуульд заасны дагуу Ирээдүйн өв санд төвлөрсөн орлогоос улсын төсөвт нийтдээ 310.0 тэрбум төгрөгийг шилжүүлснээс гадна Хүний хөгжил сангийн 1,071.9 тэрбум төгрөгийн өрийг бүрэн төлж барагдуулснаар 2019 оны 7 дугаар сараас эхлэн Ирээдүйн өв санд хуримтлал үүсэж эхэлсэн ба 2020 оны жилийн эцсийн байдлаар 1,414.2 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

4. ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН

Төсвийн тогтворжуулалтын сан нь эдийн засгийн мөчлөг болон эрдэс, түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзлээс шалтгаалсан төсвийн орлогын хэлбэлзлийг бууруулах, тогтворжуулах зорилготой баялгийн сан бөгөөд төсвийн алдагдлыг нөхөх зориулалтаар үнэ тогтвортой буюу өсөлттэй үед хуримтлуулдаг.

Уг санд 2011 оны 2 дугаар сараас хуримтлал бий болж эхэлсэн ба тус санд 2019 оны жилийн эцэст 89.7 тэрбум төгрөгийн хуримтлалтай байсан бөгөөд 2020 онд 55.1 тэрбум төгрөг төвлөрөхөөр батлагдаж, гүйцэтгэл 66.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 11.1 тэрбум төгрөг буюу 20.1 хувиар илүү төвлөрсөн байна.

Төсвийн тогтворжуулалтын сангаас Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.4-т заасны дагуу 138.8 тэрбум төгрөгийг тухайн жилийн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор улсын төсөвт шилжүүлсэн байна.

5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогод 2020 онд эрүүл мэндийн даатгалын хураамжийн шимтгэлийн орлогоор 506.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 476.5 тэрбум төгрөг төвлөрч, 94.1 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт 18. ЭМДС-ийн төсөв /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2020 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	506.5	476.5	30.0
Татварын орлого	506.5	476.5	30.0
Нийгмийн даатгалын орлого	506.5	476.5	30.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	494.5	426.4	68.1
УРСГАЛ ЗАРДАЛ	494.5	426.4	68.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25.2	14.2	11.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2.3	2.2	0.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.3	0.3	0.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.2	0.1	0.1
Хангамж, бараа материалын зардал	0.2	0.2	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	0.8	0.7	0.1
Томилолт, зочны зардал	0.1	0.1	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21.0	10.4	10.6
Бараа үйлчилгээний бусад зардал	0.3	0.2	0.1
ТАТААС	50.3	41.2	9.1
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	50.3	41.2	9.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	419.0	371.0	48.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	418.5	370.7	47.8
Засгийн газрын дотоод шилжүүлэг	418.5	370.7	47.8
Бусад урсгал шилжүүлэг	0.5	0.3	0.2
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	0.2	0.2	0.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.1	0.0	0.1
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.1	0.1	0.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.1	0.0	0.1
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	12.0	50.1	38.1
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12.0	-50.1	-38.1
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	12.0	-50.1	-38.1

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 2020 онд 426.4 тэрбум төгрөг буюу 86.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сан нь 50.1 тэрбум төгрөгийн ашигтай тайлагнагдаж байна.

6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

Нийгмийн даатгалын сангийн орлогод 2020 онд 1,812.3 тэрбум төгрөг төлөвлөснөөс 1,878.2 тэрбум төгрөг төвлөрч, 103.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Нийгмийн даатгалын сангийн орлогуудаас нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн төлбөрт 1,477.7 тэрбум төгрөг төвлөрч 104.7 хувийн биелэлттэй, улсын төсвөөс олгох татаас 399.4 тэрбум төгрөгт хүрч 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 20. НДС-ийн төсөв /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2020 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,812.3	1,878.2	65.9
Татварын орлого	1,411.7	1,477.7	65.9
Нийгмийн даатгалын орлого	1,411.7	1,477.7	65.9
Татварын бус орлого	400.5	400.5	0.0
Тусламжийн орлого	400.5	400.5	0.0
Хандив тусламж /дотоод/	400.5	400.5	0.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,494.0	2,451.8	(42.2)
УРСГАЛ ЗАРДАЛ	2,494.0	2,451.8	(42.2)
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26.5	25.9	(0.6)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21.7	21.5	(0.3)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1.1	1.1	(0.1)
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.9	0.9	(0.0)
Хангамж, бараа материалын зардал	-	-	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	0.1	0.1	(0.0)
Томилолт, зочны зардал	0.1	0.1	(0.0)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2.3	2.1	(0.1)
Бараа үйлчилгээний бусад зардал	0.2	0.1	(0.1)
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,467.6	2,425.9	(41.7)
Бусад урсгал шилжүүлэг	2,467.6	2,425.9	(41.7)
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	2,466.5	2,424.8	(41.7)
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.3	0.3	(0.0)
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.8	0.8	(0.0)
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	0.0	(0.0)
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(681.8)	(573.6)	108.2
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	681.8	573.6	(108.2)
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	681.8	573.6	(108.2)

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2020 онд 2,451.8 тэрбум төгрөгт хүрч, нийт төлөвлөгөөний 98.3 хувьтай тэнцэж байна. Ингэснээр Нийгмийн даатгалын сан нь 2020 онд 573.6 тэрбум төгрөгийн алдагдалтай тайлагнагдаж байна.

7. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Орон нутгийн 2020 оны төсвийн гүйцэтгэлээр нийт орлого 3,146.8 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 5.0 хувь буюу 164.9 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна. Харин нийт зарлага 3,157.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 15.1 хувь буюу 560.7 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

Хүснэгт 21. Орон нутгийн төсөв /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,311.7	3,146.8	(164.9)
Татварын орлого	1,287.6	1,235.5	(52.2)
Орлогын албан татвар	827.9	828.9	0.9
Хөрөнгийн албан татвар	175.3	154.9	(20.4)
Бусад татвар, төлбөр, хураамж	284.5	251.8	(32.7)
Бусад нийтлэг төлбөр, хураамж	63.6	62.8	(0.7)
Газрын төлбөр	153.5	119.7	(33.8)
Байгалийн нөөц ашигласны төлбөр	57.9	63.9	6.1
Бусад татвар	9.5	5.3	(4.2)
Татварын бус орлого	2,024.1	1,911.4	(112.7)
Нийтлэг татварын бус орлого	219.9	197.1	(22.8)
Хөрөнгийн орлого	1.5	1.2	(0.3)
Тусламжийн орлого	12.9	11.7	(1.2)
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,789.8	1,701.3	(88.4)
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,717.9	3,157.2	(560.7)
УРСГАЛ ЗАРДАЛ	2,996.7	2,592.7	(404.0)
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,357.3	2,171.2	(186.1)
ХҮҮ	6.4	6.4	0.0
ТАТААС	173.7	168.6	(5.1)
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	459.3	246.4	(212.9)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	685.5	546.8	(138.7)
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	35.7	17.8	(17.9)
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(406.2)	(10.4)	395.8
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	406.2	10.4	(395.8)
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	332.8	(10.4)	(343.2)
Өмч хувьчлал	73.4	20.8	(52.6)

Орон нутгийн орлогын 39.3 хувь татварын орлогоос, 60.7 хувь татварын бус орлогоос бүрдсэн байна. Татварын орлогын 70.0 хувь буюу 864.4 тэрбум төгрөг хувь хүний орлогын албан татвараар төвлөрсөн байна. Тайлант онд ХХОАТ-ын буцаалтаар иргэдэд 35.6 тэрбум төгрөгийг олгосон байна. Бусад татвар, төлбөр, хураамжийн орлогоор 251.8 тэрбум төгрөг төвлөрсөн байна. Татварын бус орлогын 89.0 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт /1,333.9 тэрбум/, улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг /201.7

тэрбум/, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлэг /165.7 тэрбум/ -ийн орлогууд бүрдүүлж байна.

Орон нутгийн нийт зарлага, санхүүжилтийн 82.1 хувь буюу 2,592.7 тэрбум төгрөгийг урсгал зардалд, үүнээс цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 1,384.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Хөрөнгийн зардлын гүйцэтгэл 546.8 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 138.7 тэрбум төгрөгөөр бага байна. Орон нутгийн төсвөөс улсын төсөвт 175.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

8. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2019 оны жилийн эцсийн байдлаар 24.2 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 55.1 хувьтай тэнцэж байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар 27.9 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 62.3 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 22. Засгийн газрын өрийн үлдэгдэл /тэрбум төгрөг/

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ		2019.12.31	2020.12.31
I. Засгийн газрын дотоод өр		1,399.6	1,136.6
1.1	Үнэт цаас	1,399.6	1,136.6
II. Засгийн газрын гадаад өр		20,728.1	24,851.4
2.1	Үнэт цаас	7,927.2	8,354.0
2.2	Зээл	12,800.8	16,497.3
III. Засгийн газрын өрийн баталгаа		1,076.3	1,060.4
IV. Барих-шилжүүлэх төрлийн концесс		995.7	850.2
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)		24,199.7	27,898.6
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)		20,525.6	23,024.3
Хуулиар тогтоосон өрийн хязгаар		75.0%	70.0%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ		55.1%	62.3%
Засгийн газрын өр/ДНБ		64.9%	75.5%

Засгийн газрын өрийн багцын 89.1 хувийг Засгийн газрын гадаад үнэт цаас, зээл, 4.1 хувийг Засгийн газрын дотоод үнэт цаас, 3.8 хувийг Засгийн газрын өрийн баталгаа, 3.0 хувийг “барих-шилжүүлэх” төрлийн концесс тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрт 2,576.2 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 932.8 тэрбум төгрөгийн хүү, шимтгэлийн төлбөр, нийт 3,508.9 тэрбум төгрөгийн төлбөр төлөгдсөн.

Хүснэгт 23. Засгийн газрын өрийн үйлчилгээ /тэрбум төгрөг/

№	Засгийн газрын өрийн үйлчилгээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Үндсэн төлбөр	987.2	2,576.1
1.1	2020 оны төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан үндсэн төлбөр	987.2	954.0
1.1.1	Гадаад зээл	724.2	691.0
1.1.2	Дотоод үнэт цаас	263.0	263.0
1.2	2020 оны төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан арга хэмжээ– Гадаад үнэт цаас	Өрийн зохицуулалт	1,622.1
2	Хүүгийн төлбөр	972.6	932.8


2.1	Гадаад зээл	219.2	197.9
2.2	Гадаад үнэт цаас	596.3	577.8
2.3	Дотоод үнэт цаас	157.1	157.1
3	Нийт төлбөр	1,959.7	3,508.9

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд Засгийн газрын гадаад үнэт цаасыг дахин санхүүжүүлэх зорилгоор “Номад” бондыг арилжаалж, Мазаалай болон Чингис бондын нийт 568.2 сая ам.доллар буюу 1,622.1 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийг хугацаанаас өмнө төлж барагдуулсан. Мөн Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан гадаад, дотоод зээллэгийн төлбөрт 954.0 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийг төлсөн.

8.1. ДОТООД ҮНЭТ ЦААС

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2019 оны жилийн эцсийн байдлаар 1,399.6 тэрбум төгрөг байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар 1,136.6 тэрбум төгрөг болж, 263.0 тэрбум төгрөгөөр буураад байна. Засгийн газрын дотоод өрийн үлдэгдэл буурсан нь Засгийн газар 2017 оны 10 дугаар сараас Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг зогсоож 2018-2020 онд шинээр арилжаалаагүйтэй холбоотой.

График 5. Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн мэдээлэл /тэрбум төгрөг/



Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн 727.6 тэрбум төгрөг буюу 64.0 хувийг Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаас, 374.0 тэрбум төгрөг буюу 32.9 хувийг Сайн хувьцаа хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаас, 35.0 тэрбум төгрөг буюу 3.1 хувийг Хүний хөгжил сангийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаас тус тус эзэлж байна.

Тайлант онд Засгийн газрын дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 263.0 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 157.1 тэрбум төгрөг, нийт 420.1 тэрбум төгрөгийг төлсөн. Үүнээс төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаасны үндсэн төлбөрт 220.0 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 143.5 тэрбум төгрөг, Сайн хувьцаа хөтөлбөрийн үнэт цаасны хүүгийн төлбөрт 3.75 тэрбум төгрөг, Хүний хөгжил сангийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаасны үндсэн төлбөрт 43.0 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 9.8 тэрбум төгрөгийг тус тус төлсөн.

8.2. ГАДААД ҮНЭТ ЦААС

Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2019 оны жилийн эцсийн байдлаар 7,927.2 тэрбум төгрөг байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар 8,354.0 тэрбум төгрөг болоод байна.

Хүснэгт 24. Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдлийн мэдээлэл

№	Гадаад үнэт цаас	Гаргасан дүн	Гаргасан огноо	Купон	Хугацаа	Үлдэгдэл 2020.12.31	
						USD	Тэрбум төгрөг
1	Чингис-2022	1,000.0\$	2012/12/05	5.125%	10 жил	799.2	2,277.3
2	Мазаалай	500.0\$	2016/04/06	10.875%	5 жил	132.6	377.7
3	Хуралдай	600.0\$	2017/03/09	8.750%	7 жил	600.0	1,709.7
4	Гэрэгэ	800.0\$	2017/10/26	5.625%	5.5 жил	800.0	2,279.6
5	Номад	600.0\$	2020/10/07	5.125%	5.5 жил	600.0	1,709.7
НИЙТ						2,931.7	8,354.0

Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичигт заасан 1 дүгээр зорилтын хүрээнд Засгийн газар 2020 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 600.0 сая ам.долларын "Номад" бондыг 5.125 хувийн хүүтэйгээр олон улсын зах зээлд арилжаалж 2021 оны 4 дүгээр сард төлөгдөх хуваарьтай 500.0 сая ам.долларын Мазаалай бонд, 2022 оны 12 дугаар сард төлөгдөх хуваарьтай 1.0 тэрбум ам.долларын Чингис бондын тодорхой хэсгийг тус тус буцаан худалдан авч өрийн зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Тайлант хугацаанд Засгийн газрын гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт нийт 1,622.1 тэрбум төгрөгийг төлсөн бөгөөд үүнээс Мазаалай бондын үндсэн төлбөрт 1,048.9 тэрбум төгрөг, Чингис бондын үндсэн төлбөрт 573.2 тэрбум төгрөгийг төлсөн. Засгийн газрын гадаад үнэт цаасны хүүгийн төлбөрт 577.8 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр төлөгдсөнөөс "Чингис" үнэт цаасны хүүгийн төлбөрт 141.0 тэрбум төгрөг, "Мазаалай" үнэт цаасны хүүгийн төлбөрт 156.0 тэрбум төгрөг, "Хуралдай" үнэт цаасны хүүгийн төлбөрт 147.5 тэрбум төгрөг, "Гэрэгэ" үнэт цаасны хүүгийн төлбөрт 127.0 тэрбум төгрөг, "Номад" бондын хүү шимтгэлийн төлбөрт 6.3 тэрбум төгрөгийг тус тус төлсөн.

8.3. ГАДААД ЗЭЭЛ

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 2019 оны эцэст 12,800.8 тэрбум төгрөг байсан бол 2020 оны жилийн эцэст 16,497.4 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт өрийн багцын 59.1 хувийг эзэлж байна.

Хүснэгт 25. Гадаад зээлийн үлдэгдэл /2020 оны жилийн эцсийн гүйцэтгэл тэрбум төгрөгөөр/

№	Ангилал	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хорогдсон	Ханшийн зөрүү	Эцсийн үлдэгдэл	Хувь
1	Арилжааны зээл	426.4	-	270.8	15.4	171.0	1.0
2	Төслийн зээл	9,286.3	1,390.3	352.7	778.9	11,102.8	67.3
3	Хөтөлбөрийн зээл	3,088.1	1,978.1	67.6	225.0	5,223.6	31.7
НИЙТ		12,800.8	3,368.4	691.1	1,019.3	16,497.4	100.0

Олон улсын банк, санхүүгийн байгууллага, түншлэгч орнуудын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 96 төсөл, хөтөлбөрийн хүрээнд 2020 онд нийт 3,368.4 тэрбум төгрөгийг авч ашигласнаас төслийн зээлийн ашиглалтад 1,390.3 тэрбум төгрөг, хөтөлбөрийн зээлийн ашиглалтад 1,978.1 тэрбум төгрөгийг тус тус шинээр ашигласан байна.

Хэрэгжиж буй төслүүдийн томоохон ашиглалтуудаас дурдвал: Азийн хөгжлийн банкны хөтөлбөрийн төслийн Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах төсөл 170.9 тэрбум төгрөг, Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, зам засварын төсөл-II-д 36.5 тэрбум төгрөг, Зээлийн баталгааны системийг бүрдүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг бий болгох төсөл 34.2 тэрбум төгрөг, Хөдөлмөр эрхлэх үр чадвар төсөл – 28 тэрбум төгрөг, Дэлхийн банкнаас санхүүжих буй Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл 54.0 тэрбум төгрөг, Японы Засгийн газраас зээлээр Улаанбаатар хотын шинэ олон улсын нисэх онгоцны буудал барих төсөл-II-д 43.3 тэрбум төгрөг, Хятадын засгийн газрын зээлээр Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төсөл 28 төгрөгийг тус тус олгосон байна.

Монгол Улсын Засгийн газар гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж 2020 онд гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт 889.0 тэрбум төгрөгийг төлсөн. Үүнээс 691.1 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрт, 197.9 тэрбум төгрөгийг хүүгийн төлбөрт төлсөн.

8.4. ТӨСВӨӨС ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ КОНЦЕСС

Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэгт заасны дагуу улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээ нь өрийн хэрэгсэлд тооцогдохоор хуульчилсан бөгөөд хуулийн 40.7 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, концессын гэрээний дагуу улирал бүр гарсан ашиглалтыг үндэслэж Засгийн газрын өрд бүртгэнэ” гэж заасны дагуу Сангийн яам Концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (Үндэсний хөгжлийн газар) болон орон нутгийн Засаг захиргааны байгууллагуудаас улирал бүр ашиглалт, гүйцэтгэлийн мэдээллийг авч, нэгтгэн Засгийн газрын өрд бүртгэж байна.

Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх концессын үлдэгдэл 2019 оны жилийн эцсийн байдлаар 995.7 тэрбум төгрөг байсан бол 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 850.2 тэрбум төгрөг байна. Үүнээс Улсын төсвөөс эргэн төлөгдөх нийт 10 гэрээний үлдэгдэл 849.5 тэрбум төгрөг, орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нийт 7 гэрээний үлдэгдэл 0.7 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 26. Барих-шилжүүлэх нөхцөлтэй концессын гэрээний үлдэгдэл, (тэрбум төгрөг)

“Барих-шилжүүлэх” төрлийн Концесс	Төслийн тоо	Гэрээний дүн	Үлдэгдэл
Улсын төсөв	10	1,286.1	849.5
Гүйцэтгэл 100%	8	990.2	710.4
Гүйцэтгэл 50-99%	2	295.9	139.1
Орон нутаг	6	4.9	0.7
Баянхонгор аймаг	1	3.71	0.2
Говь-Алтай аймаг	2	0.04	0.04
Завхан аймаг	1	0.52	0.1
Ховд аймаг	2	0.60	0.4
НИЙТ	16	1,291.0	850.2

8.5. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА

Засгийн газрын баталгааны үлдэгдэл 2019 оны жилийн эцсийн байдлаар 1,076.3 тэрбум төгрөг байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар 1,060.4 тэрбум төгрөг болж, 15.9 тэрбум төгрөгөөр буурсан. Үүнээс Монгол Улсын Хөгжлийн банкны баталгааны үлдэгдэл 981.3 тэрбум төгрөг, Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн баталгааны үлдэгдэл 52.3 тэрбум төгрөг, Эрдэнэс Монгол ХК-ний баталгааны үлдэгдэл 26.9 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 27. Засгийн газрын өрийн баталгааны 2020 оны үлдэгдэл

#	Баталгаа гаргуулагч	Зээлдүүлэгч	Валют	Зээллэг авсан огноо	2020.12.31		
					Үндсэн валют /сая/	Тэрбум төгрөг	Сая USD
1	МИАТ ХК	PEFCO	Ам.доллар	12/24/2013	18.3	52.3	18.3
2	Монгол Улсын Хөгжлийн банк	Japan Investors	Иен	1/6/2014	30,000.0	827.4	290.4
3	Монгол Улсын Хөгжлийн банк	China Dev. bank	Ам.доллар	9/3/2014	54.0	153.9	54.0
4	Эрдэнэс Монгол ХХК	ADB	Ам.доллар	4/1/2016	9.4	26.9	9.4
НИЙТ						1,060.4	372.1

Тайлант хугацаанд Засгийн газрын баталгаатай 2015 онд гаргасан Худалдаа хөгжлийн банкны 500.0 сая ам.долларын гадаад үнэт цаас, Засгийн газрын баталгаатай 2013 онд гаргасан “МИАТ” ТӨХК-ны 24.0 сая ам.долларын дэд зээлийн төлбөрүүдийг баталгаа гаргуулагч аж ахуйн нэгжүүд болох Худалдаа хөгжлийн банк, “МИАТ” ТӨХК бүрэн төлж дуусгаснаар Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдлээс хасагдсан. Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдлийн 78.0 хувийг эзэлж байгаа Монгол улсын хөгжлийн банкны 30.0 тэрбум иений Самурай бондын төлбөр 2023 онд төлөгдөх хуваарьтай бол “МИАТ” ТӨХК-ний зээл 2023 онд, Монгол улсын хөгжлийн банкны Хятадын хөгжлийн банкны зээл 2022 онд, Эрдэнэс Монгол ХК-ийн техник туслалцааны зээл 2031 онд тус тус төлөгдөж дуусах хуваарьтай байна.

8.6. ДАМЖУУЛАН ЗЭЭЛ

Монгол Улсын Засгийн газар 1991 оноос эхлэн Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны гишүүнээр элсэн орж олон талт болон хоёр талт зээлдүүлэгчдээс хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл, тусламж, техник туслалцааг авч ашиглаж ирсэн ба 1991-2020 он хүртэлх хугацаанд нийт 6.7 тэрбум ам.долларын гадаад зээлийг авч ашигласнаас 1.7 тэрбум ам.долларыг дотоодын аж ахуй нэгж, байгууллагад дамжуулан зээлдүүлсэн байна.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл 2019 оны эцэст 2,663.2 тэрбум төгрөг байсан бол 2020 онд 297.7 тэрбум төгрөгийг нэмж олгон, олгосон зээлийн эргэн төлөлтөд нийт 182.7 тэрбум төгрөгийн /үүнээс үндсэн төлбөрт 139.4 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 43.3 тэрбум төгрөг/ орлогыг төсөвт төвлөрүүлж жилийн эцсийн гүйцэтгэлээр үлдэгдэл 2,988.7 тэрбум төгрөг байна. Тайлант хугацааны эцсийн валютын төгрөгийн ханш суларснаас шалтгаалан дамжуулан зээлийн үлдэгдэл 165.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 28. Гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн 2020 оны жилийн эцсийн гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/

Ангилал	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хорогдсон	Ханшийн зөрүү	Эцсийн үлдэгдэл
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	1,130.6	209.7	74.2	66.5	1,420.4
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	1,058.7	19.4	19.8	60.7	1,114.2
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	474.0	68.6	45.4	38.7	454.1
НИЙТ	2,663.2	297.7	139.4	165.8	2,988.7

Хүснэгт 29. Гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл салбараар

№	Салбар	2017	2018	2019	2020
1	Жижиг дунд үйлдвэрлэл	100	114	140	204
2	Зам, тээврийн салбар	334	379	466	513
3	Нийгмийн халамжийн салбар	18	21	26	11
4	ОСНААҮ-ий салбар	458	521	639	810
5	Санхүү, эдийн засгийн салбар	142	162	199	201
6	Хувийн хэвшлийн хуулийн этгээд	215	245	300	328
7	Уул уурхайн салбар	73	83	102	90
8	Харилцаа холбооны салбар	53	61	74	59
9	Хөдөө аж ахуйн салбар	187	212	261	264
10	Эрчим хүчний салбар	327	372	456	508
	НИЙТ	1,909	2,170	2,663	2,988

Эргэн төлөлтийн талаар

Дамжуулан зээлийн эргэн төлөлтөд 2020 онд нийт 182.7 тэрбум төгрөгийг /үүнээс үндсэн төлбөрт 139.4 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 43.3 тэрбум төгрөг/ төсөвт төвлөрүүлсэн байна. Энэ нь 2019 онтой харьцуулахад 132.7 тэрбум төгрөг буюу 3.6 дахин илүү төлөлт хийгдсэн байна.

Хүснэгт 30. Дамжуулан зээлийн гэрээний дагуу төлбөрөө 2020 онд бүрэн төлж дууссан зээлүүд

Төслийн дугаар	Зээлдэгчийн нэр	Гэрээний дүн	Гэрээний валют	Хүүгийн хэмжээ	Эдийн засгийн салбар	Зээлийн хугацаа	Гэрээний байгуулсан огноо
OL-1290MON(SF)	Монголбанк	1,345,917.68	SDR	1.00	Санхүү, эдийн засаг	16	03/15/2017
OL-1510MON(SF)	Монголбанк	1,376,774.58	SDR	1.00	Санхүү, эдийн засаг	19	06/14/2017
OL-200665836	МИК	8,440,772,060.31	MNT	4.00	Санхүү, эдийн засаг	9	01/30/2011
OL-9565235	Монголбанк	3,186,370.96	EUR	0.75	Санхүү, эдийн засаг	19	12/30/2016
OL-9865775	Монголбанк	3,579,043.17	EUR	0.75	Санхүү, эдийн засаг	39	01/16/2003
OL-CLA3-JBIC	Хаан банк	3,672,000.00	USD	5.96	Санхүү, эдийн засаг	7	05/30/2017
OL-CLA3-SMBC	Хаан банк	2,448,000.00	USD	4.17	Санхүү, эдийн засаг	2	05/30/2017
OL-CLA4-JBIC	Худалдаа хөгжлийн банк	868,238,500.00	JPY	3.13	Санхүү, эдийн засаг	2	07/25/2017
OL-SW-LOAN	ЦДҮСүлжээ ТӨХК	4,052,883,245.08	MNT	0.01	Эрчим хүч	12	07/02/2008

Эргэн төлөлт хийгдэхгүй байгаа зээлийн талаар

Дамжуулан зээлийн үлдэгдэл 2020 оны жилийн эцсийн байдлаар 2,988.7 тэрбум төгрөг бол үүний 51.7 хувь буюу 1,545.3 тэрбум төгрөг нь эргэн төлөлт хийгдэж байгаа зээлийн үлдэгдэл, 48.3 хувь буюу 1,443.4 тэрбум төгрөг нь тодорхой шалтгааны улмаас эргэн төлөлт хийгддэггүй зээлийн үлдэгдэл эзэлж байна. Эргэн төлөлт хийгдэж буй зээлийн үлдэгдлийн 66.2 хувь нь хэрэгжиж буй төслүүд бол 37.8 хувь нь төсөл хэрэгжиж дууссан бөгөөд эргэн төлөгдөх шатандаа яваа зээлүүд болно.

9. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭ

I. ТӨСВИЙН ДЭМЖЛЭГ

Монгол Улсын Засгийн газар Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг арга хэмжээнд зориулж 2020 онд 532.6 сая ам.долларын санхүүжилтийг бусад улс орон, олон улсын байгууллагуудаас цар тахалтай тэмцэхэд зориулж олгосон зээл, тусламжийн хөрөнгийн төсвийн дэмжлэг хэлбэрээр хүлээн авсан байна.

УИХ-ын 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр баталсан “COVID-19 цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай” тогтоолын хүрээнд Засгийн газар эдийн засгийг дэмжих чиглэлд 5.1 их наяд төгрөгийн багц хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбогдуулан татвар, шимтгэл чөлөөлөлтийн улмаас төсвийн орлого, НДС-ийн орлого буурсныг нөхөх, хүүхдийн мөнгө, халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх, ноолуурын урамшуулал олгох зэрэг цар тахлын эсрэг авсан арга хэмжээг санхүүжүүлэхэд энэхүү төсвийн дэмжлэгүүдийг зарцуулаад байна.

№	Хөгжлийн түнш	Нийт санхүүжилт /сая ам доллар/	Гэрээ, хэлэлцээр байгуулсан огноо	УИХ, ЗГ-аар соёрхон батлуулсан огноо	Гүйцэтгэл/тайлбар
1	АХБ	100.0	2020.04.09	2020.04.23	2020.05.29 -ний өдөр хүлээн авсан. АХБ-наас хүлээн авсан 280.0 тэрбум төгрөгөөр төсвийн алдагдал нөхөхөд зориулсан (32%-тай нь тэнцэж).
2	ОУВС	99.5	2020.05.27 (Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч нарын хамтарсан хүсэлтийг ОУВС-нд илгээсэн)	-	2020.06.08-ны өдөр хүлээн авсан. ОУВС-гаас хүлээн авсан 279.0 тэрбум төгрөгөөр мөн төсвийн орлого буурсантай холбоотой төсвийн алдагдал нөхөхөд ашигласан.
3	АДБХОБ	100.0	2020.09.08	2020.10.29	2020.12.09-ний өдөр хүлээн авсан. АДБХОБ-гаас хүлээн авсан 280.0 орчим тэрбум төгрөгөөр мөн төсвийн орлого буурсантай холбоотой төсвийн алдагдлыг нөхөхөд ашигласан.
4	Япон	233.1	2020.11.24	2020.12.04	2020.12.21-ний өдөр хүлээн авсан. Япон Улсаас хүлээн авсан 688.0 орчим тэрбум төгрөгийг мөн эдийн засгийн багц арга хэмжээг хэрэгжүүлэхэд ашигласан.

II. ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ

Дахин хуваарилалт

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах чиглэлээр нийгэм, эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа 5 төсөлд дахин хуваарилалт хийх байдлаар 23.3 сая ам.долларын эх үүсвэрийг бүрдүүлж, цар тахлын эсрэг арга хэмжээнд тухайн салбарт нь зарцуулсан байна. Гүйцэтгэлийг дараах хүснэгтээс харна уу.

/сая ам.доллар/

№	Хөгжлийн түнш Төслийн нэр	Нийт санхүүжилт	Хэрэгжих хугацаа	Төслийн хүрээнд хийгдсэн, хийгдэх гол ажлууд	2020 оны гүйцэтгэл	Гүйцэтгэл
1	АХБ: Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр – 5	1.2	2020.02.01 - 2020.04.30	Зөөврийн рентген аппарат-16 ш, хяналтын монитор-43 ш, амьсгалын аппарат-32ш, тариа, дуслын автомат шахуурга-105ш, утлагын аппарат-60ш, хүчилтөрөгчийн аппарат-70ш, халуун хэмжигч-141ш, Пульсоксиметр-105ш	1.2	100%
2	ДБ: Цахим эрүүл мэнд төсөл	2.1	2020.05.01 - 2020.05.20	Суурин рентген аппарат-15 ш, зөөврийн рентген аппарат-12 ш, зөөврийн эхо аппарат-41ш, нөөцөд 26 ш.	2.1	100%
3	ДБ: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл	15.0	2017-2021	Сайн дурын даатгуулагчдыг 4, 5, 6, 7, 9, 10 дугаар саруудын шимтгэлээс чөлөөлсөнтэй холбоотой санхүүжилтэд зориулан Нийгмийн даатгалын санд шилжүүлсэн.	15.0	100%
4	ДБ: Боловсролын чанарын шинэчлэл төсөл	5.0	2015-2020	Хүүхдийн мөнгө хөтөлбөрийн 10 дугаар сарын санхүүжилтэд зарцуулсан.	5.0	100%

Санхүүжилтийн шинэ эх үүсвэр

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах чиглэлээр нийгэм, эрүүл мэндийн чиглэлээр 8 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр нийт 116.1 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, 12.8 сая ам.доллар тусламжийн эх үүсвэрийг батлуулсан. 2020 оны жилийн эцсийн байдлаар 2 төслийн хүрээнд хийгдэж буй үйл ажиллагаа бүрэн хэрэгжиж дууссан ба санхүүжилтийн гүйцэтгэлээр харахад:

№	Хөгжлийн түнш Төслийн нэр	Нийт	Хэрэг жих хугацаа	Төслийн хүрээнд хийгдсэн, хийгдэх гол ажлууд	2020 оны гүйцэтгэл	Гүйцэтгэл
Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж буй төслүүдэд						
1	ДБ /Зээл /: КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл	26.9	2020 – 2023	Дэлхийн банкны санхүүжилттэй “КОВИД 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн хүрээнд Улсын 3-р төв эмнэлэг, ХУД-т байрлах 300 ортой эмнэлэг, АШУУИС-ийн сургалтын эмнэлэг, 21 аймаг, 9 дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд нийт 1,000 орчим нэр төрлийн 11,500 гаруй тоног төхөөрөмж худалдан авах ажил хийгдэнэ. Ингэснээр тус эмнэлгүүдэд нийт 1,000 ор дэлгэн ажиллуулах боломж бүрдэж байна.	2.2	Гүйцэтгэл 8.2%
2	АХБ /Зээл /: Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр – 5 нэмэлт төсөл	30.0	2020.05.01 – 2022.04.30	Төслийн хүрээнд 7 аймгийн нэгдсэн эмнэлгийн ариутгалын тасгийг шинэчлэх, КОВИД-19 болон амьсгалын замын хүнд, хурц хэлбэрийн өвчнийг оношилж, эмчлэх зорилгоор өндөр эрсдэлтэй эмнэлгүүдэд 2923 ш тоног төхөөрөмж, 68128 ш хувийн хамгаалах хэрэгслүүдээр ханган нийлүүлэх, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулахын байгууламжийг барьж, тоноглох ажлууд хийгдэж байна. Худалдан авалтын ажлууд хийгдэж байна.	7.5	Гүйцэтгэл 25.0%
3	Япон Улс /Тусламж/: Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн буцалтгүй тусламж	9.3	2020.6.17 - 2021.11.16	Монгол-Японы сургалтын эмнэлэгт Эмнэлгийн тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашин 2021 оны 2 дугаар улиралд нийлүүлэхээр төлөвлөж байна. Түргэн тусламжийн машины нийлүүлэх гэрээ байгуулагдан, үйлдвэрлэлтэд орсон. Тусламжийн санхүүжилт Япон дахь MUFG банкин дахь Монголын Засгийн газрын дансанд орсон байгаа бөгөөд худалдан авах ажиллагаа хийгдсэний дараа санхүүжилт гарна.	-	Гүйцэтгэл 0%
4	АХБ/Тусламж/: КОВИД-19 цар тахлын эсрэг яаралтай хариу арга хэмжээ авах төсөл	1.0	2020.03.26 – 2020.09.26	СТ томографын төхөөрөмж худалдан авсан ХӨСҮТ-д олгов.	1.0	Гүйцэтгэл 100%
5	АХБ/Тусламж/: КОВИД-19 цар тахлын эсрэг яаралтай хариу арга хэмжээ авах төсөл - 2	1.5	2020.11.01 - 2021.02.30	PCR шинжилгээний лабораторид шаардлагатай 19 ширхэг тоног төхөөрөмж, тус лабораторид шаардлагатай шинжилгээний урвалж, оношлуур	-	Гүйцэтгэл 0%

Нийгмийн хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ						
6	АХБ /Зээл/: Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл	26.4	2020.04.01 – 2020.10.01	Шинэ төрлийн Коронавирус (COVID-19)-ээр үүсгэгдсэн цар тахлын нийгмийн эмзэг бүлэгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг дэмжих хүрээнд Хүүхдийн мөнгө хөтөлбөр, Хүнсний талон хөтөлбөрийн нийт 4,5,6,7,8, 10 дугаар сарын санхүүжилт хийгдсэн.	26.4	Гүйцэтгэл 100%
7	ДБ /Зээл /: Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл	20.0	2020.10.29 - 2023.12.31	Монгол Улсын дотоодын ажил горилогч, бичил бизнес эрхлэгчдийн хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх боломж, гарцыг өргөжүүлэх болон хөдөлмөр эрхлэгчдэд КОВИД19 цар тахлын хямралыг даван туулахад дэмжлэг үзүүлэх төслийн зорилтын хүрээнд Хувийн хэвшлийн даатгуулагчийг шимтгэл төлөх үүргээс түр хугацаанд чөлөөлсөнтэй холбогдуулан Нийгмийн даатгалын санд үүссэн орлогын дутагдлыг нөхөх зорилгоор 10.0 сая ам.долларыг НДС-д шилжүүлсэн.	10.0	Гүйцэтгэл 50%
8	ДБ /Тусламж/: Цар тахлын үеийн онцгой байдлын сангийн буцалтгүй тусламж	1.0	2020.09.07 - 2021.01.30	Тусламжийн хөрөнгөөр 4 сая ш бээлий, нэг удаагийн маск 206,000 ш, Н95 маск 28,000ш, хамгаалах хувцас 14,000ш, нүүрний хамгаалалт болон нүдний шил түс бүр 6,000ш зэрэг хувийн хамгаалах хэрэгслийг эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага, онцгой нөхцөлд ажиллаж байгаа гааль, татварын байгууллагуудын нэн тэргүүний эгнээнд ажиллаж байгаа ажилтнуудад олгосон.	-	Гүйцэтгэл 0%
		116.1		НИЙТ	47.1	40.6%

III. БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсын Засгийн газраас Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, ажлын байрыг хадгалах, малчин өрх болон эмзэг бүлгийн иргэдийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээг танилцуулбал:

Ажлын байрыг хадгалах: Цар тахлын үед үйл ажиллагаа нь доголдсон боловч ажлын байраа хадгалж үлдсэн ажил олгогч болон даатгуулагчийн төлөх Нийгмийн даатгалын шимтгэлийг тэглэх болон хөнгөлөх арга хэмжээг 2020 онд 2 үе шаттай авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Нийгмийн даатгалын шимтгэлийг 2020 оны 04 дүгээр сарын 01-ээс 10 дугаар сарын 01 хүртэл хугацаанд бүрэн чөлөөлсөн;
2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эрсдэл цаашид үргэлжлэх төлөвтэй байгааг харгалзан шимтгэлийн “чөлөөлөлт”-ийн арга хэмжээг 2020 оны 10-12 дугаар саруудад шимтгэлийн “хөнгөлөлт” байдлаар хэсэгчлэн үргэлжлүүлэхээр болсон. Ингэхдээ аж ахуйн нэгж,

даатгуулагчийн төлөх шимтгэлийг ажил олгогч 5%, даатгуулагч 5% байхаар тооцож холбогдох хуульд өөрчлөлт оруулсан.

Иргэдийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх: Цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалахад чиглэсэн нийгмийн халамжийн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

Хүүхдийн мөнгөн тэтгэмж: Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед 18 хүртэлх насны хүүхэд бүрд олгож байгаа хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлж 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 1,200.0 мянган хүүхдэд сар бүр 100.0 мянган төгрөг олгохоор шийдвэрлэн хэрэгжүүлсэн.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж: Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс мөн оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд сар бүр 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 288.0 мянган төгрөг олгосон.

Хүнсний талон: Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд олгож байгаа хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичгийн үнийн дүнг нэмэгдүүлж 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс мөн оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд сар бүр хүүхдэд 16,000 төгрөг, насанд хүрсэн нэг гишүүнд 32,000 тус тус олгосон.

Малчдын орлогыг нэмэгдүүлэх болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор Монгол Улсын 2019 оны жилийн эцсийн мал тооллогоор А дансанд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн, ноолуурын хэмжээг “Монгол ямааны үүлдэр, омог. Ерөнхий шаардлага” (MNS 0550:2011) стандартаар тооцож, нэг кг тутамд 20,000 төгрөгийн урамшууллыг олгосон.

/тэрбум төгрөг/

№	Арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө	Тайлбар
1	18 хүртэлх насны хүүхэд бүрт олгож байгаа хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлж 100 000 төгрөг болгон олгоход зарцуулсан нэмэлт санхүүжилт	848.6	Сар тутам 1 сая 118 мянган хүүхэд хамрагдаж байна.
2	Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд олгож байгаа хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичгийн үнийн дүнг нэмэгдүүлж хүүхдэд 16 000 төгрөг, насанд хүрсэн нэг гишүүнд 32 000 тус тус олгоход зарцуулсан нэмэлт санхүүжилт	20.0	Сар тутам 242 мянган хүн хамрагдаж байна.

3	Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж 288 000 төгрөг болгон олгоход зарцуулсан нэмэлт санхүүжилт	47.5	Сар тутам 68 мянган хүн хамрагдаж байна.
4	Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 167 дугаар тогтоолоор Коронавируст халдвар Ковид-19-ын цар тахалтай холбоотой хүүхдийн мөнгийг 100,000.00 төгрөг болгож нэмэгдүүлсэн. Уг мөнгө нэмэгдүүлсэнтэй холбоотой нийт 11,052 хүүхдэд 8.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэмж зарцуулсан байна.	8.4	Байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 11,052 хүүхдэд олгосон байна.
5	Ажилгүйдлийн даатгалын сангаас ажлын байраа хадгалж үлдсэн аж ахуйн нэгжүүдийн даатгуулагчдад олгосон дэмжлэг	44.1	7287 аж ахуйн нэгжийн 220,741 /давхардсан тоогоор/ давхардаагүй тоогоор 80,903 даатгуулагчид хамрагдсан байна.
6	Малчдын орлогыг нэмэгдүүлэх болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор Монгол Улсын 2019 оны жилийн эцсийн мал тооллогоор А дансанд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн, ноолуурын хэмжээг "Монгол ямааны үүлдэр, омог. Ерөнхий шаардлага" стандартаар тооцож, нэг кг тутамд 20 000 төгрөгийн урамшууллыг олгоход гарсан нэмэлт санхүүжилт	174.9	2019 оны мал тооллогын бүртгэлийн мэдээлэлд үндэслэн нийт 203,441 малчин, мал бүхий этгээд хамрагдсан.
	Нийт дүн	1,143.5	

--- о О о ---